



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО



Боловсрол,
шинжлэх
ухаан, оюуны
ӨМЧ

Салбарын танилцуулга
2021 он

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
БҮЛЭГ I. БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	4
1.0. 2021/20222 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ ҮР ДҮН	4
1.1 ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	5
1.2. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	6
1.2.1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага	7
1.2.2. СӨБ-ын байгууллагад хамрагдсан хүүхэд	8
1.2.3. Хамран сургалт	11
1.2.4. Цэцэрлэгийн бүлэг дүүргэлт	13
1.2.5. СӨБ-ын байгууллагын ажиллагчид	14
1.3. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	16
1.3.1. Ерөнхий боловсролын сургууль	17
1.3.2. Суралцагчид	17
1.3.3. Нэгдүгээр ангид элсэгчид	20
1.3.4. Хамран сургалт	21
1.3.5. Сургуульд хамрагдаагүй хүүхэд	22
1.3.6. Бүлэг дүүргэлт	23
1.3.7. Төгсөгчид	24
1.3.8. Элсэлтийн ерөнхий шалгалт	25
1.3.9. Ажиллагчид	25
1.4. ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	Error!
Bookmark not defined.	
1.4.1. Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага	29
1.4.2. Суралцагчид	29
1.4.3. Шинээр элсэгчид	32
1.4.4. Төгсөгчид	33
1.4.5. Ажиллагчид	34
1.5. ДЭЭД БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	35
1.5.1. Дээд боловсролын сургалтын байгууллага	36
1.5.2. Суралцагчид	37
1.5.3. Шинээр элсэгчид	42
1.5.4. Төгсөгчид	42
1.5.5. Ажиллагчид	45
1.5.6. Гадаадын их, дээд сургуульд суралцагчид	46
1.6. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ТӨСӨВ, САНХҮҮЖИЛТ	48

1.7. ШИНЖЛЭХ УХААН, ОЮУНЫ ӨМЧИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	49
1.7.1. Шинжлэх ухааны салбарын үндсэн үзүүлэлт	50
1.7.2. Оюуны өмчийн салбарын үндсэн үзүүлэлт.....	51
БҮЛЭГ II. ДҮГНЭЛТ	54
ХАВСРАЛТ	55
1. БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ	55
1.1. Боловсролын тухай ойлголт, тодорхойлолт	55
1.2. Шинжлэх ухаан, оюуны өмчийн тухай ойлголт, тодорхойлолт.....	56
2. СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР	58
3. СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН АШИГЛАЛТ	58

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ЮНЕСКО	НҮБ-ын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллага
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
НХХ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөр
ХАОСТ	Хүн ам, орон сууцны тооллого
АХС	Ажиллах хүчний судалгаа
ӨНЭЗС	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
НҮТС	Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖТБИ	Жендэрийн тэнцвэрт байдлын индекс
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс

БҮЛЭГ I. БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

1.0. 2021/2022 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ



БОЛОВСРОЛ, 2021/2022 оны хичээлийн жилийн эхэнд

ӨГӨМӨНӨН
УЛААНБААТАР



1.1 ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	2020	2021	Өсөлт, бууралт, %
Цэцэрлэгийн тоо	1454	1453	-0.1
Ерөнхий боловсролын сургууль, тоогоор	839	848	1.1
Төрийн	672	682	1.5
Хувийн	167	166	-0.6
Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, тоогоор	75	76	1.3
Их, дээд сургууль, коллеж, тоогоор	88	88	-
Төрийн	20	20	-
Хувийн	65	65	-
Олон нийтийн / шашны өмчийн	3	3	-
Сургуулийн өмнөх боловсролд хамрагдагчид	247 040	190 991	-22.7
Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчид	680 837	712 353	4.6
Бага анги	356 904	371 480	4.1
Дунд анги	222 153	238348	7.3
Ахлах анги	101 780	102 525	0.7
Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчид	40 165	42 594	6.0
Их, дээд сургууль, коллежид суралцагчид	147 293	148 954	1.1
Бүх шатны сургалтын байгууллагын үндсэн багш, мянган хүн	52.3	52.2	0.2
СӨБ-ын хамран сургалтын цэвэр жин, %	79.2	62.5	-21.1
Цэцэрлэгийн нэг багшид ногдох хүүхэд	28	22	-21.4
Бага боловсролын бүлэг дүүргэлт	32	32	0.0
Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин, %	96.1	95.7	-0.4
Дунд боловсролын хамран сургалтын цэвэр жин, %	93.6	93.8	0.2
Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин, %	95.1	95.0	-0.1
ЕБС-ийн нэгдүгээр ангид шинээр элсэгчид	78 219	75 518	-3.5
ЕБС-ийн сурагч-багшийн тооны харьцаа	20	20	0.0
Техникийн болон мэргэжлийн боловсролд суралцагчдын жендэрийн тэнцвэрт байдлын индекс	66	67	1.5
Техникийн болон мэргэжлийн боловсролд шинээр элсэгчид	22 720	22 554	-0.7
Их, дээд сургууль, коллежид суралцагчдын жендэрийн тэнцвэрт байдлын индекс	155	157	1.3
Их, дээд сургууль, коллежид шинээр элсэгчид	25 165	30 545	21.4
Улсын нэгдсэн төсвийн зарлагад боловсролын салбарын зардлын эзлэх хувь	11.8	3.5	-8.3
ДНБ-д боловсролын салбарын зардлын эзлэх хувь	4.4	1	-3.4
Шинжлэх ухааны байгууллагын тоо	68	69	1.5
Шинжлэх ухааны байгууллагын эрдмийн зэрэг, цолтой үндсэн ажиллагчид	6 109	5 907	-3.3
Хүчинтэй байгаа ашигтай загвар, тоогоор	1 067	1 026	-3.8
Хүчинтэй байгаа барааны тэмдэг, тоогоор	50 809	51 784	1.9



1.2. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

1.2.1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага

Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд СӨБ-ын зорилгыг “Бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино”¹ хэмээн тодорхойлсон.

Сургуулийн өмнөх боловсролд үзүүлж буй асран хамгаалах, сургах, тусламж үзүүлэх зэрэг нь хүүхдийг цаашдын боловсрол олж авахад чухал алхам болдог.

Монгол Улсын хэмжээнд 2010/2011 оны хичээлийн жилд нийт 839 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байсан бол тогтмол өссөөр 2021/2022 оны хичээлийн жилд 1453 болж, 615 (73.3%)-аар нэмэгдсэн байна.

2021/2022 оны хичээлийн жилд үйл ажиллагаа явуулж буй нийт цэцэрлэгийн 972 (66.9%) нь төрийн өмчийн (Улаанбаатар төмөр замын харьяа 27 цэцэрлэг), 481 (33.1%) нь хувийн өмчийн цэцэрлэг байна. Цэцэрлэгийн тоог өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад төрийн өмчийнх 24 (2.5%)-өөр нэмэгдэж, хувийн өмчийнх 25 (4.9%)-аар буурсан байна.


¹ Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль: 3 дугаар зүйл. Сургуулийн өмнөх боловсролын зорилго

Зураг 1. Цэцэрлэгийн тоо, өмчийн хэлбэрээр



Цэцэрлэгийн тоог сүүлийн 11 жилээр авч үзвэл, Улаанбаатар хотын цэцэрлэгийн тоо 2010/2011 оны хичээлийн жилд 266 байсан бол тасралтгүй өссөөр 2021/2022 оны хичээлийн жилд 2.6 дахин өссөн байна.

Зураг 2. Цэцэрлэгийн тоо, бүсээр




1.2.2. СӨБ-ын байгууллагад хамрагдсан хүүхэд

СӨБ-ын байгууллагад хамрагдсан хүүхдийн тоо 2011/2012 оны хичээлийн жилд 164.3 мянга байсан бол 2021/2022 оны хичээлийн жилд 191.0 мянга болж, 26.7 (16.3%) мянгаар өссөн байна.

СӨБ-ын байгууллагад 2021/2022 оны хичээлийн жилд хамрагдсан хүүхдийн 178.4 мянга (93.4%) нь үндсэн сургалтад хамрагдаж байгаа нь 2011/2012 оны хичээлийн жилээс 45.1 мянга (33.8%)-аар өссөн байна.


2021/2022 оны хичээлийн жилд хувилбарт сургалтад хамрагдсан 12.5 мянган хүүхдийн 1.5 мянга нь ээлжийн бүлэгт, 8.0 мянга нь нүүдлийн бүлэгт, 3.1 мянга нь явуулын багшийн сургалтаар дамжуулан сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан байна.

Зураг 3. СӨБ-ын байгууллагад хамрагдсан хүүхэд, сургалтын төрлөөр




СӨБ-ын байгууллагад 2021/2022 оны хичээлийн жилд хамрагдсан 191.0 мянган хүүхдийн 159.8 мянга (83.7%) нь төрийн өмчийн цэцэрлэгт, 31.2 мянга (16.3%) хувийн өмчийн цэцэрлэгт хамрагдаж байна.

Зураг 4. СӨБ-ын байгууллагад хамрагдсан хүүхэд, өмчийн хэлбэрээр




Сүүлийн 10 жилийн СӨБ-д хамрагдсан 5 настай хүүхдийн хамран сургалтын хувь 79.3-91.3 хувь болж өссөнийг дараах зургаас харж болохоор байна. 2011/2012 оны хичээлийн жилд СӨБ-д хамрагдсан 5 настай хүүхдийн хамран сургалт 89.1 хувьтай байсан бол 2021/2022 оны хичээлийн жилд 91.3 хувь болж 2.2 нэгж хувиар өссөн байна.

Зураг 5. СӨБ-ын байгууллагад хамрагдсан 5 настай хүүхдийн хамран сургалтын хувь



Дараах зургаас харахад сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй нийт хүүхдийн тоо 2021/2022 оны хичээлийн жилд 1065 болжээ.


Зураг 6. СӨБ-д хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо



1.2.3. Хамран сургалт


2021/2022 оны хичээлийн жилд 2-5 насны нийт хүүхдийн 62.1 хувь нь цэцэрлэгт хамрагдаж байгаа нь 2011/2012 оны хичээлийн жилээс 10.9 нэгж хувиар буурсан байна.

Зураг 7. Хамран сургалтын цэвэр жин, хувиар



Монгол Улсын 2-5 насны хүн амд СӨБ-д хамрагдсан хүүхдийн эзлэх хувийг аймгаар авч үзвэл, Дундговь аймагт хамгийн бага (50.9%), Говь-Сүмбэр аймагт хамгийн өндөр (91.9%²) байна.


Зураг 8. СӨБ-д хамрагдсан хүүхдийн эзлэх хувь, аймаг, нийслэлээр, 2021/2022 оны хичээлийн жилд



СӨБ-д хамрагдсан хүүхдийн эзлэх хувь Улаанбаатар хотод 57.6 хувь байгаа бөгөөд дүүргээр авч үзвэл, Багахангай дүүрэгт хамгийн бага (46.2%), Хан-Уул дүүрэгт хамгийн өндөр (65.9%) байна.

² Говь-Сүмбэр аймгийн СӨБ-ын байгууллагад зэргэлдээ аймаг, сумдын хүүхэд хамрагддаг.

Зураг 9. СӨБ-д хамрагдсан хүүхдийн эзлэх хувь, нийслэл, дүүргээр, 2021/2022 оны хичээлийн жилд



1.2.4. Цэцэрлэгийн бүлэг дүүргэлт


Цэцэрлэгийн бүлэг дүүргэлт энэ хичээлийн жилд 24 болж өмнөх хичээлийн жилээс 5-аар буурахад Ковид-19 цар тахлын улмаас бүлэг дүүргэлтийг 20-25 байхаар зааж, 3 настай хүүхдийг цэцэрлэгт хамруулаагүйтэй холбоотой.

Зураг 10. Цэцэрлэгийн бүлэг дүүргэлт, хүүхдээр, бүлгээр, 2021/2022 оны хичээлийн жилд



2021/2022 оны хичээлийн жилд Улаанбаатар хотын цэцэрлэгийн нэг бүлэг дунджаар 36 хүүхэдтэй байна. Харин энэ үзүүлэлтийг дүүргээр харуулбал, нэг бүлэгт ногдох хүүхдийн тоогоор Сонгинохайрхан дүүрэг (38) хамгийн өндөр, Багахангай дүүрэг (27) хамгийн цөөхөн нь байна.


Зураг 11. Улаанбаатар хотын цэцэрлэгийн бүлэг дүүргэлт, хүүхдээр, дүүргээр, 2021/2022 оны хичээлийн жилд



1.2.5. СӨБ-ын байгууллагын ажиллагчид


2021/2022 оны хичээлийн жилд СӨБ-ын байгууллагад нийт 31.0 мянган хүн ажиллаж байгаагийн 8.8 мянга буюу 28.5 хувь нь үндсэн багш, 7.8 мянга нь буюу 25.1 хувь нь туслах багш байна. 2021/2022 оны хичээлийн жилд үндсэн багшийн тоо 2011/2012 оны хичээлийн жилээс 3.9 мянга (79.8%)-аар, харин туслах багшийн тоо 3.5 мянга (80.0%)-аар нэмэгдсэн байна.

Зураг 12. СӨБ-ын байгууллагын нийт ажиллагчид, мянган хүн




Улсын хэмжээнд 2021/2022 оны хичээлийн жилд нэг багшид 22 хүүхэд ногдож байна. Харин нэг багшид ногдох хүүхдийн тоогоор Дорноговь (18) хамгийн бага байгаа бол Төв аймагт хамгийн өндөр (29) байна.

Зураг 13. Нэг багшид ногдох хүүхдийн тоо, аймаг, нийслэлээр, 2021/2022 оны хичээлийн жилд



Энэ үзүүлэлтийг нийслэл, дүүргээр харвал, Баянзүрх дүүрэгт (23) хамгийн өндөр, Багахангай дүүрэгт (16), Багануур дүүрэгт (14) хамгийн бага байна.

Зураг 14. Нэг багшид ногдох хүүхдийн тоо, нийслэл, дүүргээр, 2021/2022 оны хичээлийн жилд





1.3. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

1.3.1. Ерөнхий боловсролын сургууль


2021/2022 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 848 сургууль үйл ажиллагаа явуулж байгаагийн 72 (8.5%) нь бага сургууль, 109 (12.9%) нь дунд сургууль, 667 (78.7%) нь ахлах сургууль байна. Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын 80.4 хувь нь төрийн өмчийн, 19.6 хувь нь хувийн өмчийн сургууль байна.

Зураг 15. Ерөнхий боловсролын сургууль, өмчийн хэлбэрээр



2021/2022 оны хичээлийн жилд нийт сургуулийн 563 (66.4%) нь хөдөөд, 285 нь (33.6%) хотод сургалтын үйл ажиллагаа эрхэлж байна.


Зураг 16. Ерөнхий боловсролын сургууль, хот, хөдөөгөөр



1.3.2. Суралцагчид


2021/2022 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд нийт 717.5 мянган (өдрөөр 712.4 мянга, орой, эчнээгээр 135, дүйцсэн хөтөлбөрөөр 5.0 мянга) суралцагчид суралцсан байна.

Зураг 17. Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид, сургалтын хэлбэрээр, дүнд эзлэх хувиар




2021/2022 оны хичээлийн жилд өдрөөр нийт 712.3 мянган хүүхэд суралцаж байгаагийн 92.5 хувь нь төрийн өмчийн сургуульд, 7.5 хувь нь хувийн өмчийн сургуульд суралцаж байна.

Зураг 18. Ерөнхий боловсролын сургуулийн өдрөөр суралцагчид, өмчийн хэлбэрээр




2021/2022 оны хичээлийн жилд ахлах ангид 102.5 мянган хүүхэд суралцаж байгаагийн 45.4 хувь нь хөвгүүд, 54.6 хувь нь охид байна.

Зураг 19. Ерөнхий боловсролын сургуулийн өдрөөр суралцагчид, 2021/2022 оны хичээлийн жилд



2021/2022 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 5.6 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа нь өмнөх хичээлийн жилээс 22 (0.4%)-оор, 2011/2012 оны хичээлийн жилээс 12.4 мянга (68.9 %) -аар тус тус буурсан байна.

Зураг 20. ЕБС-д суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд



Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны тоо 2021/2022 оны хичээлийн жилд 548 болж, өмнөх оны хичээлийн жилээс 8-аар, 2011/2012 оны хичээлийн жилээс 29-өөр тус тус нэмэгджээ.

2021/2022 оны хичээлийн жилд дотуур байранд амьдрах хүсэлт гаргасан 34.5 мянган хүүхдээс 32.6 мянга (94.3%) нь дотуур байранд амьдарч байгаа нь 2011/2012 оны хичээлийн жилээс 2.7 нэгж хувиар нэмэгдсэн байна.

Зураг 21. Хүсэлт гаргасан нийт хүүхэд болон дотуур байранд амьдарч буй хүүхдийн эзлэх хувь



2021/2022 оны хичээлийн жилд ЕБС-д малчдын 128.2 мянган хүүхэд суралцаж байгаа нь 2011/2012 оны хичээлийн жилтэй харьцуулахад 10.1 мянга (8.5%)-аар нэмэгдсэн байна. Малчин өрхийн нийт хүүхдийн 32.6 мянга (25.4 %) нь дотуур байранд амьдарч байна.


Зураг 22. Ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа малчин өрхийн нийт болон дотуур байранд амьдарч буй хүүхэд, мянган хүүхэд



1.3.3. Нэгдүгээр ангид элсэгчид

2021/2022 оны хичээлийн жилд нэгдүгээр ангид шинээр нийт 75.5 мянган хүүхэд элссэний 88.5 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан байна.

Зураг 23. Нэгдүгээр ангид шинээр элсэгчдийн тоо болон сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь




1.3.4. Хамран сургалт

Хамран сургалтын цэвэр жинг тооцохдоо аль нэг боловсролын түвшний тухайн насны суралцагчдын тоог тухайн насны хүн амын тоонд харьцуулж тооцсон бөгөөд бага боловсролын (1-5-р анги) хамран сургалтын цэвэр жин 2021/2022 оны хичээлийн жилд 95.7 хувь болж, 2011/2012 оны хичээлийн жилээс 1.6 нэгж хувиар, өмнөх хичээлийн жилээс 0.4 нэгж хувиар тус тус буурсан байна.


Дунд ангийн (6-9-р анги) хамран сургалтын цэвэр жин 2021/2022 оны хичээлийн жилд 93.8 хувь болж, 2011/2012 оны хичээлийн жилээс 19.1 нэгж хувиар өссөн байна.

Зураг 24. Хамран сургалтын цэвэр жин, хувиар



Улсын хэмжээнд бага боловсролын (1-5 дугаар анги) хамран сургалтын бохир жин (нас харгалзахгүйгээр тооцсон) 2021/2022 оны хичээлийн жилд 97.0 хувь болж, өмнөх оны хичээлийн жилээс 0.3 нэгж хувиар буурсан байна. Бага боловсролын хамран сургалтын бохир жинг аймгаар авч үзвэл, хамгийн өндөр нь Орхон аймагт (101.3 %), хамгийн бага нь Булган аймагт (89.5 %) байна.


Зураг 25. Бага боловсролын хамран сургалтын бохир жин, хувиар, аймгаар, 2021/2022 оны хичээлийн жилд



1.3.5. Сургуульд хамрагдаагүй хүүхэд

2021/2022 оны хичээлийн жилд бага боловсролд хамрагдвал зохих 6-10 настай нийт хүүхдийн 3.0 хувь буюу 11.4 мянган хүүхэд, дунд ангид хамрагдвал зохих 11-14 насны нийт хүүхдийн 3.7 хувь буюу 9.2 мянган хүүхэд сургуульд хамрагдаагүй байна. Харин дунд ангид хамрагдаагүй нийт хүүхдийг хүйсээр авч үзвэл 59.4 хувь нь эрэгтэй хүүхэд байна.

Зураг 26. Сургуульд хамрагдаагүй хүүхэд, ангиар, 2021-2022 он




1.3.6. Бүлэг дүүргэлт

ЕБС-ийн нэг бүлэгт ногдох хүүхдийн тоо сүүлийн 8 жилийн хугацаанд аажмаар өсөж, 2021/2022 оны хичээлийн жилд улсын хэмжээнд нэг бүлэгт 30 хүүхэд, бага ангийн нэг бүлэгт 32 хүүхэд суралцаж байгаа нь улсын хэмжээнд тогтоосон стандартын³ дагуу байна.

Бага ангийн бүлэг дүүргэлтийг өмчийн хэлбэрээр авч үзэхэд, төрийн өмчийн сургуулийн нэг бүлэгт 31 хүүхэд, хувийн өмчийн сургуулийн нэг бүлэгт 20 хүүхэд суралцаж байна.


Зураг 27. ЕБС-ийн бүлэг дүүргэлт, хүүхдээр



ЕБС-ийн бага боловсролын бүлэг дүүргэлтийг аймаг, нийслэлээр авч үзвэл, хамгийн их нь Улаанбаатар хот, Орхон аймагт (36), хамгийн бага нь Говь-Алтай аймагт (22) байна.


³ БСШУ-ны сайд, НХХ-ийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 307/91/237 дугаар тушаалын 1.4-т заасан "Анги дүүргэлтийг бага ангид 30-35 хүүхэдтэй байх"-аар тогтоосон.

Зураг 28. ЕБС-ийн бага боловсролын бүлэг дүүргэлт, хүүхдээр, аймаг, нийслэлээр, 2021/2022 оны хичээлийн жилд



Мөн энэ үзүүлэлтийг дүүргээр авч үзвэл, Сонгинохайрхан дүүрэгт (38) хамгийн өндөр, Багахангай дүүрэгт (27) хамгийн бага байна.


Зураг 29. ЕБС-ийн бага боловсролын бүлэг дүүргэлт, хүүхдээр, дүүргээр, 2021/2022 оны хичээлийн жилд



1.3.7. Төгсөгчид

2020/2021 оны хичээлийн жилд ЕБС-ийг нийт 79.7 мянган хүүхэд (9 дүгээр ангийг 44.9 мянга, 12 дугаар ангийг 34.8 мянга) өдрөөр суралцан төгссөн нь 2011/2012 оны хичээлийн жилээс 25.8 мянгаар буурсан байна.


Зураг 30. ЕБС-ийг нийт өдрөөр суралцан төгсөгчид, ангиар, 2011-2020 он



1.3.8. Элсэлтийн ерөнхий шалгалт

Их, дээд сургуульд 2021 онд элсэгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтын дүн буюу хэмжээст оноо (хэмжээст оноо гэдэг нь тухайн хичээлийн нийт гүйцэтгэлийг шалгалтад орсон шалгуулагчдын гүйцэтгэлтэй харьцуулан хэмжээслүүлсэн оноо)-г хүйсээр авч үзвэл, охид өндөр оноо авсан байна.

Зураг 31. Элсэлтийн ерөнхий шалгалтын дүн (хэмжээст оноо), хүйсээр, 2021 он



1.3.9. Ажиллагчид

Ерөнхий боловсролын сургуулийн ажиллагчдын тоо 2011/2012 оны хичээлийн жилд 44.6 мянга байсан бол 2021/2022 оны хичээлийн жилд 56.2 мянга болж, 11.6 мянга (26.0%)-аар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Ерөнхий боловсролын сургуулийн нийт ажиллагчид болон үндсэн багшийн тоо

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Ажиллагчид	44 618	45 363	45 367	45 882	46 791	47 168	47 991	49 441	51 550	54 498	56 228
Үндсэн багш	26 492	26 863	27 205	27 449	28 490	28 889	29 242	30 411	32 085	34 073	35 110
Бага ангийн	8 916	8 895	8 795	8 901	9 877	9 976	10 238	10 736	11 030	11 467	11 820
Дунд ангийн	11 217	10 877	11 184	11 233	11 454	11 708	11 960	12 670	13 703	14 694	15 399
Ахлах ангийн	6 359	7 091	7 226	7 315	7 159	7 205	7 044	7 005	7 352	7 912	7 891

2021/2022 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд нийт 35.1 мянган үндсэн багш ажиллаж байгаагийн 28.6 мянга (81.6%) нь эмэгтэй багш байна.


Үндсэн багш нарыг насны бүлгээр авч үзвэл 30-39 насныхан хамгийн их буюу 12.9 мянга (36.8%) байгаа бол 60 ба түүнээс дээш насны 522 (1.5%) үндсэн багш байна.

Хүснэгт 2. Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багшийн тоо

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Үндсэн багш	26 492	26 863	27 205	27 449	28 490	28 889	29 242	30 411	32 085	34 073	35 110
Эмэгтэй	21 717	21 936	22 051	22 285	23 120	23 479	23 876	24 879	26 149	27 729	28 642
Боловсролын зэргээр											
Доктор	21	28	15	23	22	23	23	19	18	25	30
Магистр	3 013	3 144	3 220	3 670	4 085	3 983	4 034	4 347	4 767	5 373	5 959
Бакалавр	17 647	18 354	19 065	19 441	20 142	20 949	21 185	22 301	23 722	26 024	26 644
Диплом	5 685	5 236	4 732	4 263	3 916	3 530	3 131	2 901	2 721	2 580	2 340
Бусад	126	101	173	52	325	404	869	843	857	71	137
Насны бүлгээр											
30 нас хүртэл	8 651	8 444	8 370	8 222	8 469	8 378	8 331	8 606	8 912	9 147	9 058
30-39 нас	9 067	9 422	9 686	10 011	10 277	10 406	10 526	10 741	11 361	12 339	12 913
40-49 нас	5 505	5 455	5 519	5 688	6 056	6 520	6 807	7 317	7 820	8 482	8 794
50-59 нас	3 114	3 353	3 447	3 369	3 515	3 389	3 365	3 462	3 607	3 650	3 823
60, түүнээс дээш	155	189	183	159	173	196	213	285	385	455	522
Ажилласан жилээр											
1 жил хүртэл	1 138	1 205	934	611	2 110	1 675	1 732	1 838	2 072	2 013	2 092
1-5 жил	6 531	6 116	6 585	8 196	8 869	9 405	9 287	9 919	8 296	9 279	9 272
6-10 жил	5 918	6 256	6 554	6 974	5 740	5 892	5 866	5 752	7 705	7 573	7 258
11-15 жил	3 666	3 851	4 115	4 158	4 785	4 348	4 576	4 825	5 307	5 686	5 808
16-20 жил	2 422	2 455	2 524	2 465	2 321	2 669	2 900	3 082	3 348	3 836	4 382
21-25 жил	2 636	2 584	2 312	1 979	1 396	1 420	1 446	1 562	1 733	1 993	2 245
26, түүнээс дээш	4 181	4 396	4 181	3 066	3 269	3 480	3 435	3 433	3 624	3 693	4 053


2021/2022 оны хичээлийн жилд улсын хэмжээнд ЕБС-ийн нэг багшид 20 хүүхэд ногдож байгаа бол бага ангийн нэг багшид 31 хүүхэд ногдож байна. Харин нэг багшид ногдох хүүхдийн тоог аймгаар авч үзвэл, Баян-Өлгий, Говь-Алтай аймагт хамгийн бага (15) байгаа бол Улаанбаатар хот, Дорноговь аймагт хамгийн өндөр (22) байна.


Зураг 32. Сурагч-багшийн тооны харьцаа (нэг багшид ногдох сурагчийн тоо), аймаг, нийслэлээр, 2021/2022 оны хичээлийн жилд



Нэг багшид ногдох суралцагчийн тоог дүүргээр авч үзвэл, 2021/2022 оны хичээлийн жилд энэхүү үзүүлэлт Сонгинохайрхан дүүрэгт хамгийн өндөр (24), харин Багахангай дүүрэгт хамгийн бага (20) байна.

Зураг 33. Сурагч-багшийн тооны харьцаа (нэг багшид ногдох сурагчийн тоо), нийслэл, дүүргээр, 2021/2022 оны хичээлийн жилд






1.4. ТЕХНИКИЙН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

1.4.1. Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага

Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын тоо 2011/2012 оны хичээлийн жилд 71 байсан бол 2021/2022 оны хичээлийн жилд 76 болж, 5 (7.0%)–аар нэмэгдсэн байна.

Зураг 34. Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын тоо, өмчийн хэлбэрээр




2021/2022 оны хичээлийн жилд техникийн болон мэргэжлийн боловсролын 76 сургууль сургалтын үйл ажиллагаа явуулж байгаагийн 56.6 хувь нь төрийн өмчийнх, 43.4 хувь нь хувийн өмчийнх байна.

1.4.2. Суралцагчид

Суралцагчдын тоо 2011-2017 онуудад тасралтгүй буурсан бол 2018/2019 оны хичээлийн жилээс бага зэрэг өсөж, 2021/2022 оны хичээлийн жилд 42.6 мянга болсон байна.


Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчдыг хүйсээр авч үзвэл, 2011/2012 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 26.4 мянга (54.9%) нь эрэгтэй суралцагчид байсан бол энэ үзүүлэлт 2021/2022 оны хичээлийн жилд 25.5 мянга (59.9%) болсон байна.

Зураг 35. Нийт суралцагчид, хүйсээр




Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын тоог аймгаар авч үзвэл, 2021/2022 оны хичээлийн жилд суралцагчдын 20.9 мянга (49.1%) нь Улаанбаатар хотод, 2.9 мянга (5.9%) нь Дархан-Уул аймагт, 1.6 мянга (3.9%) нь Төв аймагт, 17.5 мянга (41.1%) нь бусад аймагт суралцаж байна.

Зураг 36. Нийт суралцагчид, аймгаар, хүйсээр, 2021/2022 оны хичээлийн жилд




Мэргэжлийн боловсролд суралцагчдын жендэрийн тэнцвэрт байдал (ЖТБ⁴)-ын индекс буюу мэргэжлийн боловсрол эзэмшихээр суралцаж буй 100 эрэгтэй суралцагч тутамд ногдож буй эмэгтэй суралцагчдын тоо 2021/2022 оны хичээлийн жилд 67 байна.

Зураг 37. Жендэрийн тэнцвэрт байдлын индекс



Суралцагчдыг сургалтын төрлөөр нь авч үзвэл, 2021/2022 оны хичээлийн жилд нийт 42.6 мянган суралцагчдын 37.3 мянга (87.6%) нь мэргэжлийн боловсролд, 4.8 мянга (11.4%) нь техникийн боловсролд, 0.4 мянга (1.0%) нь мэргэжлийн сургалтад суралцаж байна.

Зураг 38. Нийт суралцагчид, сургалтын төрлөөр



Суралцагчдын тоог салбараар авч үзвэл, 2021/2022 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 13.2 мянга (30.9%) нь аж үйлдвэрийн салбарын мэргэжлийг, 9.1 мянга (21.3%) нь барилгын салбарын мэргэжлийг тус тус сонгон суралцсан байна. Харин эрүүл мэндийн чиглэлээр 254 (0.6%) суралцагч суралцаж байгаа нь өмнөх оны хичээлийн жилтэй харьцуулахад 84 (49.4%)-өөр өссөн байна.


⁴ Жендэрийн тэнцвэрт байдлын индекс нь тухайн шатны боловсролыг эзэмшиж буй 100 эрэгтэй тутамд ногдох эмэгтэйн тоог харуулна.

Зураг 39. Нийт суралцагчид, мэргэжлийн чиглэлээр



Тээвэр, уул уурхай, барилгын салбаруудыг эрэгтэй оюутан илүүтэй сонгон суралцаж байгаа бол эмэгтэй оюутнууд эрүүл мэнд, үйлчилгээний салбарт илүүтэй суралцаж байна.

Зураг 40. Нийт суралцагчид, хүйсээр, салбараар, дүнд эзлэх хувиар, 2021/2022 оны хичээлийн жилд



1.4.3. Шинээр элсэгчид

2021/2022 оны хичээлийн жилд техникийн болон мэргэжлийн боловсролын байгууллагад шинээр элсэгчдийн 7.9 мянга (35.1%) нь тухайн жилд суурь боловсрол эзэмшигчид байна.


Зураг 41. Шинээр элсэгчид, тухайн жилд суурь боловсрол эзэмшигчид



1.4.4. Төгсөгчид

2020/2021 оны хичээлийн жилд нийт 19.7 мянган оюутан төгссөн нь 2011/2012 оны хичээлийн жилээс 3.4 мянга (14.6%)-аар буурсан байна.


Зураг 42. Нийт төгсөгчид, хүйсээр



1.4.5. Ажиллагчид

Үндсэн багшийн тоо 2011/2012 оны хичээлийн жилд 2093 байсан бол 2021/2022 оны хичээлийн жилд 2124 болж, 31 (1.5%)-ээр өссөн байна.

Зураг 43. Ажиллагчид болон үндсэн багш





1.5. ДЭЭД БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

1.5.1. Дээд боловсролын сургалтын байгууллага

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллежийн тоо 2011/2012 оны хичээлийн жилд 101 байсан бол 2021/2022 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллежийн тоо 88 болж, 13 (12.9%)-аар буурсан байна.


Үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллежийн тоог өмчийн хэлбэрээр авч үзвэл, 2011/2012 оны хичээлийн жилд нийт их, дээд сургууль, коллежийн 86 (85.1%) нь хувийн өмчийн, 15 (14.9%) нь төрийн өмчийн сургууль эзэлж байсан бол 2021/2022 оны хичээлийн жилд 65 (73.9%) хувийн өмчийн, 20 (22.7%) төрийн өмчийн, харин 3 (3.4%) нь олон нийтийн/шашны өмчийн⁵ сургууль байна.

Зураг 44. Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо, өмчийн хэлбэрээр



2021/2022 оны хичээлийн жилд дээд боловсролын сургалтын нийт 88 байгууллагын 53.4 хувь нь дээд сургууль, 43.2 хувь нь их сургууль, 3.4 хувь нь коллеж эзэлж байна.

Зураг 45. Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо, ангиллаар




⁵ Дээд боловсролын салбарын статистикийн мэдээллийн маягт 2020 онд шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор байгууллагын өмчийн хэлбэрийн ангилалд өөрчлөлт орж, олон нийтийн/шашны өмчийн гэсэн ангилал нэмэгдсэн болно.

1.5.2. Суралцагчид

Их, дээд сургууль, коллежид суралцагчид 2011/2012 оны хичээлийн жилд 172.8 мянга байсан бол 2021/2022 оны хичээлийн жилд 149.0 мянга болж, 13.8 хувиар буурсан байна.


Их, дээд сургууль, коллежийн суралцагчдыг хүйсээр авч үзвэл, 2011/2012 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 101.6 мянга (58.8%) нь эмэгтэй суралцагчид байсан бол 2021/2022 оны хичээлийн жилд энэ үзүүлэлт 91.0 мянга болж, 10.5 мянга (10.4%) аар буурсан байна.

Зураг 46. Нийт суралцагчид, хүйсээр




Их, дээд сургууль, коллежид суралцагчдыг аймгаар авч үзвэл, 2021/2022 оны хичээлийн жилд нийт 148.9 мянган суралцагчдын 139.4 мянга (93.6%) нь Улаанбаатар хотод, 3.6 мянга (2.4%) нь Дархан-Уул аймагт, 6.0 мянга (4.0%) нь бусад аймагт суралцаж байна.

Зураг 47. Нийт суралцагчид, аймгаар, хүйсээр, 2021/2022 оны хичээлийн жилд




2021/2022 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллежийн бакалаврын хөтөлбөрт хамрагдагчдыг насны ангиллаар авч үзвэл, 38.2 хувь нь 18-21 насны эмэгтэй, 25.0 хувь нь 18-21 насны эрэгтэй суралцагчид байгаа бол 1.7 хувийг 40-өөс дээш насны суралцагчид⁶ эзэлж байна.

Зураг 48. Бакалаврын хөтөлбөрт хамрагдагчид, насны ангиллаар, 2021/2022 оны хичээлийн жилд



Өнгөрсөн жилүүдийн тоон мэдээллээс харахад, дээд боловсролын байгууллагад суралцагчдын жендэрийн тэнцвэрт байдлын индекс буюу дээд боловсрол эзэмшихээр суралцаж буй 100 эрэгтэй суралцагч тутамд ногдож буй эмэгтэй суралцагчдын тоо 2021/2022 оны хичээлийн жилд 157 байгаа нь 2011/2012 оны хичээлийн жилээс нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Зураг 49. Жендэрийн тэнцвэрт байдлын индекс



Их, дээд сургууль, коллежийн суралцагчдыг боловсролын зэргээр авч үзвэл, 2021/2022 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 117.0 мянга (78.6%) нь бакалавр⁷, 25.3 мянга (17.0%) нь магистр, 3.5 мянга (2.3%) нь докторын зэрэг эзэмшихээр суралцаж байна. Суралцагчдын тоог 2011/2012 оны хичээлийн жилтэй харьцуулахад бакалаврынх 37.8 мянга (24.4%)-аар буурсан бол магистрынх 10.4 мянга (70.1)-аар, докторынх 413 (13.5%)-аар тус тус өссөн байна.

⁶ Их, дээд сургууль, коллежийн бакалаврын хөтөлбөрт 40-өөс дээш насны эрэгтэй, эмэгтэй суралцагчдыг оруулсан.

⁷ Бакалаврын зэргийн суралцагчдад дипломын дээд боловсролын зэргийн суралцагчдыг оруулсан.

Хүснэгт 3. Нийт суралцагчид, боловсролын зэргээр

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Бүх суралцагчид	172 798	175 591	174 075	178 295	162 626	157 138	155 248	157 625	148 446	147 293	148 954
Үүнээс: Эмэгтэй	101 557	102 427	101 783	102 520	93 674	91 526	90 094	93 552	90 573	89 463	91 034
Дипломын дээд Үүнээс: Эмэгтэй	-	-	-	-	-	-	124	362	98	124	3 155
Бакалавр Үүнээс: Эмэгтэй	154 876	155 801	152 708	155 839	140 296	133 223	130 484	130 545	119 203	119 108	117 037
Магистрантур Үүнээс: Эмэгтэй	90 227	90 103	88 399	88 457	79 790	76 753	74 883	76 394	71 622	71 375	69 803
Докторантур Үүнээс: Эмэгтэй	14 873	16 630	18 063	19 065	19 005	20 066	20 345	22 499	25 753	24 813	25 300
Докторантур Үүнээс: Эмэгтэй	9 505	10 420	11 437	12 103	11 957	12 552	12 697	14 554	17 066	16 291	16 717
Докторантур Үүнээс: Эмэгтэй	3 049	3 160	3 304	3 391	3 325	3 849	4 295	4 219	3 392	3 248	3 462
Докторантур Үүнээс: Эмэгтэй	1 825	1 904	1 947	1 960	1 927	2 221	2 493	2 413	1 871	1 780	1 995

Нийт суралцагчдыг мэргэжлийн чиглэлээр авч үзвэл, 2021/2022 оны хичээлийн жилд 43.0 мянга (28.8%) нь бизнес, удирдахуй, хууль, эрх зүйн чиглэлд суралцаж байгаа нь өмнөх оны хичээлийн жилтэй харьцуулахад 4.8 мянга (10.1%)-аар, 18.3 мянга (12.8%) нь инженер, үйлдвэрлэл, барилга угсралтын чиглэлд суралцаж байгаа нь өмнөх оны хичээлийн жилтэй харьцуулахад 745 (4.1%)-аар өссөн байна.

Зураг 50. Нийт суралцагчид, дүнд эзлэх хувиар, мэргэжлийн чиглэлээр⁸




Суралцагчдын тоог мэргэжлийн чиглэлээр авч үзвэл, 2011/2012 оны хичээлийн жилд 61.0 мянга (35.3%) нь, 2021/2022 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 51.6 мянга (34.7%)

⁸ Мэргэжлийн чиглэлийн ангиллыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/78, 2014 оны А/370, 2015 оны А/138, 2015 оны А/262, 2017 оны А/52, 2019 оны А/336 дугаар тушаалын "Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай" хавсралтаар батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх диплом, бакалавр, магистр, докторын мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/ индекс", ЮНЕСКО-гоос 2013 онд гаргасан "Боловсролын мэргэжлийн чиглэл-ISCED-F"-ийг баримтална.

нь нийгмийн ухааны салбарын мэргэжлийг сонгосон байна. Харин инженер, үйлдвэрлэл, барилга угсралтын мэргэжлээр суралцагчдын тоо 10 жилийн өмнөхтэй харьцуулахад 13.5 мянга (41.5%)-аар буурсан байна.

Зураг 51. Нийт суралцагчид, мянган хүн, мэргэжлийн чиглэлээр




Инженер, үйлдвэрлэл, барилга угсралт болон мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбаруудыг эрэгтэй оюутан илүүтэй сонгожээ. Тухайлбал, одоогоос 10 жилийн өмнө буюу 2010/2011 оны хичээлийн жилд инженер, үйлдвэрлэл, барилга угсралтыг салбарт нийт 30.0 мянган оюутан суралцаж байсны 68.3 хувь нь, 2021/2022 оны хичээлийн жилд 19.1 мянган оюутан суралцаж байсны 72.7 хувь нь эрэгтэй байна. Харин боловсролын болон анагаах ухааны салбарыг эмэгтэйчүүд илүүтэй сонгон суралцаж байна.

Зураг 52. Нийт суралцагчид, хүйсээр, дүнд эзлэх хувиар, мэргэжлийн чиглэлээр



Монгол Улсад 2021/2022 оны хичээлийн жилд нийт 1547 гадаад оюутан суралцаж байгаагийн 76.4 хувь хөрш зэргэлдээ БНХАУ-ын оюутнууд байна.


Зураг 53. Монгол Улсад суралцаж буй гадаад оюутан, нийт дүнд эзлэх хувиар, улсаар, 2020/2021 оны хичээлийн жилд



1.5.3. Шинээр элсэгчид

2021/2022 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллежид 30.5 мянган оюутан шинээр элссэн байгаагийн 18.7 мянга буюу 61.5 хувь нь эмэгтэй байна.


Зураг 54. Шинээр элсэгчид, хүйсээр



1.5.4. Төгсөгчид

Их, дээд сургууль, коллежийг 2011/2012 оны хичээлийн жилд нийт 37.7 мянган оюутан төгссөн бол 2020/2021 оны хичээлийн жилд 31.2 мянга болж, 6.6 мянга (17.5%)-аар буурсан байна. 2020/2021 оны хичээлийн жилийн нийт төгсөгчдийн 19.9 мянга (63.7%) нь эмэгтэй байна. Их, дээд сургууль, коллежийг 2020/2021 оны хичээлийн жилд нийт 31.2 мянган оюутан төгссөн нь өмнөх оны хичээлийн жилээс 3.1 мянга (11.1%)-аар өсжээ.

Зураг 55. Нийт төгсөгчид, хүйсээр



Нийт төгсөгчдийг боловсролын зэргээр авч үзвэл, 2020/2021 оны хичээлийн жилд 25.8 мянга (82.9%) нь бакалавр⁹, 5.3 мянга (16.9%) нь магистр, 44 (0.1%) нь докторын зэрэг эзэмшсэн байна. 2011/2012 оны хичээлийн жилээс бакалаврын төгсөгчид 8.2 мянга (24.0%)-аар, докторынх 55 (55.6%)-аар буурч, магистрынх 1 647 (45.4%)-аар өссөн байна.

Хүснэгт 4. Нийт төгсөгчид, боловсролын зэргээр

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Бүх төгсөгчид	37 749	37 243	33 850	35 181	35 889	34 681	29 164	23 038	28 045	31 161
Эмэгтэй	24 339	23 949	21 662	21 857	21 848	21 179	17 476	13 513	17 262	19 861
Дипломын дээд	918	1 181	259	93	231	495	45	409	268	117
Эмэгтэй	655	910	121	25	128	364	17	68	96	90
Бакалавр	33 106	32 234	29 477	29 728	30 663	30 301	25 120	18 951	23 081	25 727
Эмэгтэй	21 211	20 521	18 799	18 410	18 529	18 379	14 932	11 195	14 112	16 056
Магистр	3 626	3 697	3 996	5 254	4 859	3 772	3 868	3 574	4 531	5 273
Эмэгтэй	2 412	2 434	2 676	3 358	3 104	2 374	2 446	2 185	2 959	3 687
Доктор	99	131	118	106	136	113	131	104	165	44
Эмэгтэй	61	84	66	64	87	62	81	65	95	28

Нийт төгсөгчдийг мэргэжлийн чиглэлээр авч үзвэл, 2020/2021 оны хичээлийн жилд 9.7 мянга (31.4%) нь бизнес, удирдахуй, хууль, эрх зүйн чиглэлээр төгссөн нь өмнөх оны төгсөгчидтэй харьцуулахад 332 (3,5%)-оор өссөн бол үйлчилгээний чиглэлээр 2020/2021 оны хичээлийн жилд 1.3 мянга (4.0%) суралцагч төгссөн нь өмнөх оны төгсөгчидтэй харьцуулахад 0.8 мянга (2 дахин)-аар нэмэгдсэн байна.


⁹ Бакалаврын зэргээр төгсөгчдөд дипломын дээд боловсролын зэргээр төгсөгчдийг оруулсан.

Зураг 56. Нийт төгсөгчид, дүнд эзлэх хувиар, мэргэжлийн чиглэлээр




Төгсөгчдийн тоог салбараар авч үзвэл, 2020/2021 оны хичээлийн жилд нийт төгсөгчдийн 9.8 мянга (31.4%) нь, 2010/2011 оны хичээлийн жилд 10.7 мянга (28.3%) нь бизнес, удирдахуй, хууль, эрх зүйн салбарын мэргэжлийнх байна.

Зураг 57. Нийт төгсөгчид, мянган хүн, мэргэжлийн чиглэлээр



2010/2011 оны хичээлийн жилд инженер, үйлдвэрлэл, барилга угсралтын салбарт 4.2 мянган оюутан төгссөний 60.2 хувь нь, 2020/2021 оны хичээлийн жилд 4.1 мянган оюутан төгссөний 70.1 хувь нь эрэгтэй байна. Харин анагаах ухааны салбарт 2010/2011 оны хичээлийн жилд 3.2 мянган оюутан төгссөний 83.4 хувь нь, 2020/2021 оны хичээлийн жилд 3.7 мянган оюутан төгссөний 86.5 хувь нь эмэгтэй байна.


Зураг 58. Нийт төгсөгчид, хүйсээр, дүнд эзлэх хувиар, мэргэжлийн чиглэлээр



1.5.5. Ажиллагчид


Их, дээд сургууль, коллежийн ажиллагчдын тоо 2011/2012 оны хичээлийн жилд 13.0 мянга байсан бол 2021/2022 оны хичээлийн жилд 12.2 мянга болж, 846 (6.5%)-гаар буурсан байна.

Зураг 59. Их, дээд сургууль, коллежийн ажиллагчид, өмчийн хэлбэрээр




Их, дээд сургууль, коллежийн үндсэн багшийн тоог хүйсээр авч үзвэл, 2021/2022 оны хичээлийн жилд 3.7 мянга (61.3%) нь эмэгтэй байгаа нь 10 жилийн өмнөхтэй харьцуулахад 0.5 мянга (12.8%)-аар буурсан байна.

Зураг 60. Их, дээд сургууль, коллежийн үндсэн багш, эрэгтэй/эмэгтэй багшийн дүнд эзлэх хувиар



2010/2011 оны хичээлийн жилд нэг багшид 24 оюутан ногдож байсан бол 2021/2022 оны хичээлийн жилд мөн адил 24 оюутан ногдож байна.


Зураг 61. Нэг багшид ногдох суралцагчид



1.5.6. Гадаадын их, дээд сургуульд суралцагчид


Засгийн газар хоорондын хэлэлцээрийн, төрийн сангийн зээлээр 2021 онд гадаадын их, дээд сургуульд нийт 1144 оюутан элссэний 85.7 хувь нь Засгийн Газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу, 14.3 хувь нь Боловсролын зээлийн сангийн зээлийн санхүүжилтээр суралцаж байна.

Зураг 62. Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр, төрийн сангийн зээлээр гадаадын их, дээд сургуульд суралцагчид



Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу 2021 онд суралцаж буй 1144 суралцагчдыг суралцаж буй улсаар нь харуулбал, ОХУ-д 48.1 хувь нь, Унгар улсад 16.1 хувь нь, Польш улсад 8.7 хувь нь, Америк улсад 6.6 хувь нь, Хятад улсад 3.4 хувь нь, Австрали улсад 3.4 хувь нь, Англи улсад 3.1 хувь нь, Канад улсад 2.5 хувь нь, Польш 1.9 хувь нь суралцаж байгаа бол Франц, Казахстан, БНСУ, Болгар, Их Британи, Украин, Румын, Япон, Итали, Швейцар, Тайвань, Сингапур, Шинэ Зеланд улсад 0.1-1.1 хувь нь суралцаж байна.

Зураг 63. Засгийн Газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу суралцагчид, суралцаж буй улсаар, 2020/2021 он




1.6. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ТӨСӨВ, САНХҮҮЖИЛТ

Монгол Улсын нэгдсэн төсвөөс боловсролын салбарт 2011 онд 678.0 тэрбум төгрөгийг зарцуулж байсан бол 2021 онд 539.4 тэрбумд хүрч, 138.7 тэрбум (20.5%)-аар буурсан байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлагын дүнд боловсролын салбарын зардлын эзлэх хувийг авч үзвэл, 2011 онд 13.6 хувь байсан бол 2021 онд 3.5 хувь болж, 10.1 нэгж хувиар, харин дотоодын нийт бүтээгдэхүүнд боловсролын салбарын зардлын эзлэх хувь 2011 онд 5.1 хувь байсан бол 2021 онд 1.3 хувь болж, 3.8 нэгж хувиар тус тус буурсан байна.

Зураг 64. Улсын нэгдсэн төсвийн зарлага болон ДНБ-д боловсролын салбарын зардлын эзлэх хувь






1.7. ШИНЖЛЭХ УХААН, ОЮУНЫ ӨМЧИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

1.7 ШИНЖЛЭХ УХААН, ОЮУНЫ ӨМЧИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

1.7.1. Шинжлэх ухааны салбарын үндсэн үзүүлэлт

Шинжлэх ухааны 69 байгууллага 2021 онд үйл ажиллагаа явуулсан байна. Шинжлэх ухааны салбарын нийт зардал 2021 онд 48.2 тэрбум төгрөг байгаа нь дотоодын нийт бүтээгдэхүүний 0.1 хувийг эзэлж, 2011 оноос 0.1 нэгж хувиар буурсан байна.

Зураг 65. ДНБ-д шинжлэх ухааны салбарын зардлын эзлэх хувь



2011 онд шинжлэх ухааны байгууллагад нийт 2.6 мянган үндсэн ажиллагчид байсны 53.0 хувь нь эмэгтэй байсан бол 2021 онд нийт 5.9 мянган үндсэн ажиллагчид байгаагийн 60.4 хувь нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 5. Эрдмийн зэрэг, цолтой үндсэн ажиллагчид

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Үндсэн ажиллагчид	2 583	2 672	2 694	2 724	2 515	2 211	3 482	3 246	3 352	6 109	5 907
Эмэгтэй	1 368	1 409	1 388	1 411	1 277	1 132	1 932	1 565	1 700	3 573	3 570
Шинжлэх ухааны доктор	127	124	143	135	95	77	130	109	136	153	133
Боловсролын доктор	478	487	486	496	495	432	797	706	657	1697	2000
Академич	50	48	48	46	38	32	46	56	38	64	57
Профессор	167	157	176	166	125	77	221	157	136	369	436
Дэд профессор	116	117	116	106	98	74	239	187	166	564	666

Улсын төсвөөс 2021 онд нийт 456 эрдэм шинжилгээний ажлыг санхүүжүүлсний 86.2 хувийг суурь судалгааны ажил төсөл эзэлж байна.

Хүснэгт 6. Улсын төсвөөс санхүүжүүлсэн судалгаа хөгжүүлэлтийн ажил


Судалгааны ажлын төрөл	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Бүгд	454	453	506	429	366	319	276	320	309	353	456
Суурь судалгааны ажил*	270	271	333	271	206	160	94	131	94	265	393
Хэрэглээний судалгааны ажил *	148	145	141	135	160	159	169	189	215	78	47
Туршилт, хөгжүүлэлтийн ажил*	36	37	32	23	-	-	13	-	-	10	16

*ШУТ-ийн салбарын захиргааны болон албан ёсны статистикийн мэдээний маягт, аргачлал 2020 онд шинэчлэгдсэнтэй холбоотойгоор үзүүлэлтүүд шинэчлэгдсэн.

1.7.2. Оюуны өмчийн салбарын үндсэн үзүүлэлт

Иргэн, хуулийн этгээдээс 2021 онд ирүүлсэн 407 бүтээлд патент олгосны 186 нь шинэ бүтээлийнх, 221 нь бүтээгдэхүүний загварынх байгаа нь өмнөх оноос шинэ бүтээлийн патент 62 (50.0%)-оор өсөж, харин бүтээгдэхүүний загварын патент 4 (1.8%)-өөр буурчээ.


Зураг 66. Патент



Тайлбар: Оюуны өмчийн патентын мэдүүлгийн анхдагч огнооноос хойш 9 сарын дотор шүүлтийн дүгнэлтийг үндэслэн патент олгох эсэх талаар шийдвэр гаргадаг тул тухайн бүрт олгосон патент нь патентын мэдүүлгээс их байж болно.

Оюуны өмчийн байгууллагад ашигтай загварын гэрчилгээ авахаар 2021 онд 173 иргэн, хуулийн этгээд мэдүүлэг гаргасан нь өмнөх оноос 49 (22.1%)-өөр буурчээ. Мөн иргэн, хуулийн этгээдийн ирүүлсэн 107 ашигтай загварт гэрчилгээ олгосон нь өмнөх оноос 90 (45.7%)-ээр буурсан байна.

Зураг 67. Ашигтай загвар



Бүтээлээ зохиогчийн эрхээр хамгаалуулахаар 2021 онд иргэн, хуулийн этгээдээс нийт 1114 мэдүүлэг гаргаснаас бүх бүтээлд шинээр зохиогчийн эрхийн гэрчилгээ олгосон нь өмнөх оноос 54 (5.1%)-өөр өсжээ.

Хүснэгт 7. Зохиогчийн эрх, төрлөөр

Төрөл	2016	2017	2018	2019	2020	2021
Нийт зохиогчийн эрхийн мэдүүлэг	1 025	674	1 072	1 007	1 060	1 114
Шинжлэх ухаан, утга зохиолын бичмэл буюу аман төрөлд хамаарах бүтээл, түүнчлэн компьютерын программ	-	597	938	748	763	511
Хөгжмийн урлагийн үгтэй болон үггүй бүтээл	-	19	40	6	106	299
Дүрслэх урлагийн төрөлд хамаарах бүтээл	-	14	21	65	43	70
Чимэглэх болон хавсарга урлаг, тайз чимэглэлийн төрөлд хамаарах бүтээл	-	-	2	1	-	85
Архитектурын бүтээл, уран баримал, уран барилгын төрөлд хамаарах бүтээл	-	8	15	14	30	74
Бүжгийн урлагийн бүтээл	-	-	-	13	-	38
Жүжиг, хөгжимт жүжиг, тайзны урлагийн төрөлд хамаарах бүтээл	-	-	-	1	7	17
Гэрэл зургийн болон түүнтэй төсөөтэй аргаар туурвисан бүтээл	-	-	1	3	-	7
Дуу авиа бүхий дүрст бүтээл /телевизийн нэвтрүүлэг, кино урлагийн бүтээл/	-	32	35	46	46	2
Үүсмэл бүтээлийн төрөлд хамаарах бүтээл	-	2	18	39	18	4
Материалыг нь сонгон түүвэрлэх, байршуулах зэргээр бүтээлч хөдөлмөрийн үр дүнд бий болсон, өөрийн бүтэц агуулгаараа оюуны бүтээлд тооцогдох тайлбар толь, лавлах, зохиолын цоморлог, өгөгдөхүүн-мэдээллийн сангийн бусад эмхэтгэлүүдийн төрөлд хамаарах бүтээл	-	2	2	69	47	6
Ардын урлагийн бүтээлд тулгуурлан туурвисан үүсмэл бүтээлийн төрөлд хамаарах бүтээл	-	-	-	2	-	1
Бусад зохиогчийн оюуны бүтээлч үйл ажиллагааг илэрхийлэхүйц бүтээл	-	-	-	-	-	-
Зохиогчийн эрхээр хамгаалах бүтээлд олгосон гэрчилгээ	1 025	674	1 072	1 007	1 060	1 114

Монгол Улсын хэмжээнд 2021 оны байдлаар хүчинтэй 51.8 мянган барааны тэмдэгт байна. Барааны тэмдгийн эрхийн хамгаалалт авахаар 2021 онд 4642 иргэн, хуулийн этгээд мэдүүлэг гаргасан байна. Нийт мэдүүлсэн барааны тэмдгийн 1918 (41.3%) нь Мадридын хэлэлцээрийн дагуу Монгол Улсыг нэр зааж гаргасан олон улсын мэдүүлэг байна. Мөн иргэн, хуулийн этгээдийн ирүүлсэн 3308 барааны тэмдэгт эрхийн хамгаалалт олгосон нь өмнөх оноос 720 (17.9%)-оор буурч, 1796 барааны тэмдгийг бүртгэхээс татгалзсан байна.

Хүснэгт 8. Барааны тэмдэг болон газарзүйн заалт

Үзүүлэлт	Барааны тэмдэг					
	2016	2017	2018	2019	2020	2021
Нийт барааны тэмдэг болон газар зүйн заалтын мэдүүлэг	3 400	3 803	4 374	4 603	4 190	4 642
Дотоодын мэдүүлэг	1 140	1 351	1 431	1 581	1 663	2 222
Иргэн	304	332	354	480	529	725
Хуулийн этгээд	836	1 019	1 077	1 101	1 134	1 497
Гадаадын мэдүүлэг	557	468	576	619	529	502
Иргэн	16	8	5	20	7	7
Хуулийн этгээд	541	460	571	599	522	495
Олон улсын мэдүүлэг ¹	1 703	1 984	2 367	2 403	1 998	1 918
Иргэн	10	19	10	58	52	79
Хуулийн этгээд	1 693	1 965	2 357	2 345	1 946	1 839
Нийт эрхийн хамгаалалт олгосон барааны тэмдэг болон газар зүйн заалт	2 605	3 318	3 505	3 927	4 028	3 308
Хүчинтэй байгаа барааны тэмдэг	-	-	45 696	47 983	50 809	51 784

**Барааны тэмдгийн эрхийн хамгаалалт авахаар Мадридын хэлэлцээр болон Протоколын дагуу мэдүүлсэн Монгол Улсыг нэр зааж гаргасан олон улсын мэдүүлэг.*

БҮЛЭГ II. ДҮГНЭЛТ

- ✓ ДНБ-д боловсролын салбарын зардлын эзлэх хувь 1.3 хувь, шинжлэх ухааны салбарын эзлэх хувь 0.1 байна. Энэ нь цаашид дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх боловсрол, шинжлэх ухааны салбарын нийт зардлын хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.
- ✓ СӨБ-д хамрагдсан хүүхдийн тоо 191.0 мянга болж өмнөх оноос 56.0 (22.7%) мянгаар буурсан нь ковид-19 цар тахлын улмаас 4-5 настай хүүхдийг үндсэн сургалтад хамруулж, 3 настай хүүхдийн хөгжлийг гэр бүлд түшиглэн зайны хэлбэрээр дэмжин ажиллаж байгаатай холбоотой. Цэцэрлэгийн нэг бүлэгт ногдох хүүхдийн тоог байршлаар авч үзвэл улсын хэмжээнд (24), аймгаар авч үзвэл Архангай, Говьсүмбэр, Сүхбаатар аймагт хамгийн их (27), байгаа бол хамгийн бага дүүргэлттэй нь Дорноговь, Булган зэрэг аймгуудад (20) байна.
Харин бүлгээр харуулбал, хамгийн олон хүүхэдтэй нь дунд, ахлах, бэлтгэл бүлэг 24 байгаа бол хамгийн цөөхөн хүүхэдтэй нь бага бүлэг (18), холимог бүлэг (21) байна. 2021/2022 оны хичээлийн жилийн эхэнд ЕБС-ийн бага ангийн бүлэг дүүргэлт хөдөө орон нутагт стандарт хэмжээнд байна. Харин нийслэлийн Сонгинохайрхан, Чингэлтэй, Багануур, Баянгол, Налайх дүүрэгт бага ангийн бүлэг дүүргэлт 36-38 байгаа нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд (хуучин нэрээр), Сангийн сайдын хамтарч баталсан стандартад анги дүүргэлтийг бага ангид 30-35 хүүхэдтэй байхаар тогтоосноос давсан байна.
- ✓ 2020/2021 онд суурь боловсролыг 44850 сурагч өдрөөр суралцан төгссөний 17.6 хувь нь 2021/2022 оны хичээлийн жилд техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад шинээр элссэн байна. Иймд суурь болон бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөгчдөөс техникийн болон мэргэжлийн боловсролд суралцагчдын тоог тогтмол нэмэгдүүлэх нь хүн амын ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйчүүд, ядуурлыг бууруулахад эергээр нөлөөлөх юм.
- ✓ 2021/2022 оны хичээлийн жилд мэргэжлийн боловсролд суралцаж буй 100 эрэгтэй суралцагч тутамд 67 эмэгтэй ногдож байгаа бол дээд боловсролд суралцаж буй 100 эрэгтэй оюутан тутамд 157 эмэгтэй ногдож байгаа нь жендэрийн тэнцвэрт байдал алдагдаж буйг харуулж байна.
- ✓ Дээд боловсролын сургалтын байгууллага нийслэлд төвлөрдөг. Жилд дунджаар 30-40 мянган хүүхэд дунд сургууль төгсдөг. Үүний 40% нь Улаанбаатар хотод, 60% нь орон нутагт боловч төгсөгчдийн 91% нь Улаанбаатар хотын сургуулиудад, зөвхөн 9% нь орон нутгийн сургуульд элсэж байгаа нь орон нутагт суралцах оюутны хувьд мэргэжлийн сонголт хязгаарлагдмал байгаатай холбоотой байна. Их, дээд сургууль, коллеж төгсөгчдийн мэргэжлийн тэргүүлэх чиглэлийг харахад Бизнес, удирдахуй, хууль, эрх зүй, эрүүл мэнд, нийгмийн халамж, боловсрол тэргүүлж байна. Төгсөгчдийг хүйсээр авч үзэхэд инженер, үйлдвэрлэл, барилга угсралтын чиглэлээр төгсөгчдийн дийлэнх (70.1 хувь) нь эрэгтэй, бусад салбарын хувьд эмэгтэйчүүд нь дийлэнх байв. Дээд боловсролын сургалтын байгууллагын байршлаас үл хамааран хөдөө, орон нутагт чанартай боловсрол эзэмших тэгш боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц бодлого боловсруулж, бүс нутаг, орон нутгийн нийгэм эдийн засгийн байдлыг сайжруулах, хот хөдөөгийн ялгааг багасгах асуудал тулгарч байна.¹⁰

¹⁰ Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030

1. БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

1.1. Боловсролын тухай ойлголт, тодорхойлолт

Монгол Улсын “Боловсролын тухай” хуулийн 4 дүгээр зүйлд “Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино” гэж заасан.

Монгол Улсын “Боловсролын тухай” хуульд заасны дагуу манай улсын боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролын нэгдэл байх бөгөөд сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол, дээд боловсролоос бүрдэнэ.

Хүний түвшинд боловсрол гэдэгт хүний өөрийгөө боловсруулж хөгжүүлэхийн тулд ухамсартайгаар хийж байгаа танин мэдэхүйн үйл ажиллагаа, түүний үр дүнг ойлгоно.

Нийгмийн түвшинд боловсрол гэдэгт иргэдийн сурч боловсрох, хөгжих эрхээ эдлэхэд нь төр, нийгмийн зүгээс дэмжлэг үзүүлж байгаа үйлчилгээ, түүний үр дүнг ойлгоно.

Сургалтын байгууллага гэж боловсролын нэг буюу хэд хэдэн түвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлдэг хуулийн этгээдийг ойлгоно гэж тодорхойлсон.

Боловсролын түвшин: Тухайн шатанд эзэмшвэл зохих сургуулийн өмнөх, бага, дунд, дээд боловсролын агуулгын стандартаар тогтоосон мэдлэгийн хэмжээ юм.

Албан боловсрол: Боловсролын албан ёсны байгууллагаар дамжуулж, суралцагчийн ерөнхий болон мэргэжлийн зохих түвшний боловсрол эзэмших хэрэгцээг хангадаг боловсролын зохион байгуулагдсан үйл ажиллагаа юм.

Албан бус боловсрол: Боловсролын албан ёсны тогтолцооноос гадуур иргэнд боловсролын үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалттай үйл ажиллагаа юм.

Насан туршийн боловсрол: Бүх насны иргэд боловсролын албан болон албан бус хэлбэрээр ёс суртахуун, гоо зүй, иргэн, гэр бүл, шинжлэх ухаан, амьдрах ухааны боловсролыг тасралтгүй эзэмших үйл ажиллагааг ойлгоно.

Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино.

“Бүх нийтийн ерөнхий боловсрол” гэж 12 жилийн сургалтын агуулгын түвшинг, “суурь боловсрол” гэж 9 жилийн сургалтын агуулгын түвшинг ойлгодог. Бага, дунд боловсролын сургалтын байгууллага нь ерөнхий боловсролын сургууль юм.

Мэргэжил гэж тодорхой ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадлын цогцыг хэлнэ /Монгол Улсын “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хууль/.

Мэргэжлийн боловсрол гэж тодорхой мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшлийг хэлнэ гэж тодорхойлжээ /Монгол Улсын “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хууль/.

Дээд боловсролын зорилго нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн иргэнд дээд боловсрол олгоход оршино. Дээд боловсролын сургалтын байгууллага нь их сургууль, дээд сургууль, коллеж байна.

Хамран сургалтын бохир жинг тооцохдоо нас харгалзалгүйгээр боловсролын тухайн түвшинд суралцагчдын тоог энэ түвшний боловсрол эзэмших насны нийт хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

Хамран сургалтын цэвэр жинг тооцохдоо аль нэг боловсролын түвшний тухайн насны суралцагчдын тоог тухайн насны хүн амын тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

Сурагч-багшийн тооны харьцааг боловсролын тухайн түвшний боловсролын байгууллагад суралцагчдын тоог энэ түвшний багшийн тоонд харьцуулж тодорхойлно.

Сургуульд суралцах хугацаа гэж тухайн насны суралцагчийн ирээдүйд суралцах жилийн нийлбэр болно. Тухайн суралцагчийн тодорхой насандаа сургуульд элсэн орох магадлал нь одоогийн хамран сургалтын жинтэй тэнцүү гэж үздэг.

Жендерийн тэнцвэрт байдлын индекс гэж тодорхой нэг үзүүлэлтийн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн тоон харьцааг ойлгоно.

Дотоодын нийт бүтээгдэхүүнд боловсролын төсвийн зардлын эзлэх хувь гэж тайлант хугацаанд улсын төсвөөс боловсролын салбарт зарцуулж байгаа урсгал болон хөрөнгө оруулалтын зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг хэлнэ. Боловсролын салбарт зарцуулж байгаа нийт зардлыг тооцохдоо холбогдох бүх яам, бүх шатны засаг захиргааны байгууллага, агентлаг, бие даасан институтийг хамарна.

Улсын нэгдсэн төсвийн зарлагад боловсролын төсвийн зардлын эзлэх хувь гэж Улсын төсвөөс боловсролын салбарт зарцуулсан нийт зардлыг тухайн жилийн улсын нэгдсэн төсвийн нийт зарлагад харьцуулж, хувиар илэрхийлнэ.

Эмэгтэй багш нарын эзлэх хувь гэж нэг хичээлийн жилд тухайн боловсролын түвшинд ажиллаж байгаа эмэгтэй багш нарын нийт багшийн дүнд эзлэх хувь болно.

1.2. Шинжлэх ухаан, оюуны өмчийн тухай ойлголт, тодорхойлолт

Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа: Эдийн засаг, нийгмийн болон бусад асуудлыг шийдвэрлэх цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор судалгаа хөгжүүлэлтийн ажил гүйцэтгэх, шинжлэх ухаан, технологийн боловсрол олгох болон шинжлэх ухаан, технологийн үйлчилгээ үзүүлэх цогц үйл ажиллагааг хэлнэ.

Шинэ технологи: Оюуны бүтээлийг хэрэглээний бүтээгдэхүүн болгон хувиргахад чиглэгдсэн хүн, техник, мэдээлэл, зохион байгуулалтын харилцан уялдаатай үйл ажиллагааг хэрэгжүүлэх аргуудын цогц юм.

Шинэ биет бүтээгдэхүүн: Биет шинж чанартай, эзэмшигчдээ онцгой эрх, эдийн засгийн үр өгөөж авчирдаг хөрөнгө.

Эрдмийн зэрэг: Судалгаа хөгжүүлэлтийн ажилд оролцсон ажиллагчдыг эрдмийн зэргээр ангилан бичнэ.

Эрдэм шинжилгээний ажилтан: Шинжлэх ухаан, технологийн тодорхой чиглэлээр эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил гүйцэтгэдэг мэргэшсэн судлаачийг хэлнэ.

Шинжлэх ухааны доктор: Эрдэм шинжилгээний ажлын үр дүнг хэлэлцэн Шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн хуралдааны шийдвэрийг үндэслэн Монгол Улсын шинжлэх ухааны академийн ерөнхийлөгчийн тушаалаар олгодог эрдмийн зэрэгтэй СХА-д оролцсон ажилтныг хамруулна.

Боловсролын доктор: Их сургууль зэрэг судалгааны чиг баримжаатай мэргэжлийн боловсролын байгууллагуудад шинэлэг, дэвшилтэт судалгааны ажил гүйцэтгэсэн

суралцагчдад олгодог эрдмийн зэрэг юм. Докторын хөтөлбөрүүд нь шинжлэх ухааны болон мэргэжлийн салбараар төрөлждөг.

Суурь судалгаа: Аливаа үзэгдэл, ажиглаж болохуйц баримт, нотолгоонд түшиглэн, шинэ мэдлэгийг бий болгоход чиглэсэн, тодорхой хэрэглээнд анхнаасаа ашиглахыг зориогүй, туршилтын буюу онолын судалгааны ажил юм. Суурь судалгаа нь судлагдахууны шинж чанар, бүтэц, өөр хоорондын харилцан хамааралд дүн шинжилгээ хийх замаар таамаглал, онол, зүй тогтлыг шинээр томъёолох, туршихад чиглэнэ. Хүн, нийгэм, хүрээлэн байгаа орчны хөгжлийн үндсэн зүй тогтлын талаар шинэ мэдлэг бий болгоход чиглэсэн туршилтын болон онолын үйл ажиллагааг ойлгоно (Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 3.1.3-р заалт).

Хэрэглээний судалгаа (хавсарга судалгаа): Тодорхой үр дүн гаргахад чиглэсэн, шинэ мэдлэг бий болгох зорилготой судалгааны ажил бөгөөд суурь судалгааны ололт, үр дүнг тодорхой хэрэглээнд ашиглаж болох эсэхийг тодорхойлох, тодорхой зорилгод хүрэх арга замыг тогтооход чиглэгдэнэ. Хэрэглээний судалгааны үр дүн нь тодорхой бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, арга зүй, тогтолцоонд ашиглагдахад зориулагдсан байдаг (Фраскатын гарын авлага, ЭЗХАХБ, 2015 он).

Туршилт, хөгжүүлэлтийн ажил: Шинэ бараа, материал, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мөн шинэ үйл явц, тогтолцоо, үйлчилгээг нэвтрүүлэх, эдгээрийг сайжруулахад чиглэсэн системтэй судалгаа, туршилтын ажлыг ойлгоно (Фраскатын гарын авлага, ЭЗХАХБ, 2015 он).

Оюуны өмч: Оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон зохиогчийн эрхийн бүтээл, зохиогчийн эрхэд хамаарах эрхийн объект болон аж үйлдвэрийн өмчийг ойлгоно (Монгол Улсын Оюуны өмчийн тухай хуулийн 3.1.1).

Барааны тэмдгийн эрхийн хамгаалалт: Иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийллийг ойлгоно (Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 3.1.1).

Зохиогчийн эрхийн гэрчилгээ: Зохиогчид өөрсдийн уран зохиолын болон урлагийн бүтээлүүдийн эзэмших эрхийг ашиглахад хэрэглэдэг хуулийн нэр томъёо юм. Зохиогчийн эрхийн бүтээлд ном, хөгжим, уран зураг, уран баримал, кино, компьютерийн програм, мэдээллийн сан, зар сурталчилгаа, газрын зураг, техникийн зураг зэрэг бүтээл багтдаг.

Газарзүйн заалтын эрхийн хамгаалалт: Тухайн газар нутгийн байгаль, цаг уурын нөхцөл, эсхүл тухайн газар нутгийн хүмүүсийн дадал заншил зэрэг хүчин зүйлээр тодорхойлогдсон чанар, нэр хүнд, бусад онцлог шинж чанар бүхий бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн улс, бүс, газар нутгийн газар зүйн тодорхойлолт юм (Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 3.1.4 заалт).

Патент: Тухайн шийдэл нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар болохыг тодорхойлж, зохиогч нь тодорхой хугацаанд түүнийг өмчлөх онцгой эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч, төрийн эрх бүхий байгууллагаас олгож байгаа баримт бичгийг ойлгоно (Монгол Улсын ын Патентийн тухай хуулийн 3.1.4-р заалт).

Шинэ бүтээл: Байгалийн хуульд тулгуурлан сэдэж, үндэслэлийг нь тодорхойлсон, үйлдвэрлэх арга ажиллагаа болон бүтээгдэхүүнд хамаарах, шинэ бүтээлийн түвшин агуулсан шинэ шийдлийг ойлгоно (МУ-ын Патентийн тухай хуулийн 3.1.1).

Бүтээгдэхүүний загвар: Бүтээгдэхүүний гадаад хэлбэр, хийцэд хамаарах гоёл чимэглэл, өнгө, өнгөний хослол агуулсан, шинээр зохион бүтээсэн, өвөрмөц шийдлийг ойлгоно (Монгол Улсын ын Патентийн тухай хуулийн 3.1.2).

Ашигтай загвар: Үйлдвэрлэлийн багаж, хэрэгсэл, аргад хамаарах, үйлдвэрлэлд ашиглах боломжтой техникийн шинэ шийдлийг ойлгоно (Монгол Улсын Үн Патентийн тухай хуулийн 3.1.3).

2. СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР

Боловсролын салбарын статистикийн мэдээллийн гол эх үүсвэр нь Боловсрол, шинжлэх ухааны яам болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиргааны статистикийн мэдээлэл байдаг. Түүнчлэн 10 жил тутам явагддаг ХАОСТ болон өрхөд суурилсан түүвэр судалгаанууд (АХС, ӨНЭЗС, НҮТС гэх мэт)-аас боловсролын статистикийн үзүүлэлтийг тооцон гаргаж байна. Боловсролын статистикийн захиргааны мэдээллийг тогтоосон хугацаанд цэцэрлэг, бүх шатны сургуулиас цуглуулдаг.

Мөн шинжлэх ухааны салбарын статистик мэдээллийг Боловсрол, шинжлэх ухааны яамны захиргааны маягтын дагуу жилд нэг удаа, оюуны өмчийн статистикийн мэдээллийг Оюуны өмчийн газраас сар бүр албан ёсны маягтын дагуу цуглуулж байна.

3. СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН АШИГЛАЛТ

Боловсролын статистик нь хүний амьдралын чанарын болон улс орны хөгжлийн чухал үзүүлэлтүүдийг бүрдүүлдэг. НҮБ-ын Статистикийн хүрээлэнгээс 2009 онд хэвлэн гаргасан боловсролын үзүүлэлтүүдийн техникийн гарын авлагыг үндэслэн үндэсний боловсролын статистикийн үзүүлэлт тооцох аргачлалыг 2013 онд батлан, уг аргачлалын дагуу үзүүлэлтүүдийг тооцон гаргаж байна.

Түүнчлэн олон улсын боловсролын стандарт ангилал (ISCED 2011)-д нийцүүлэн Монгол улсын боловсролын ангилал, кодыг 2013 онд баталж, тооллого, судалгаа болон боловсролын бусад мэдээлэлд ашиглаж байна.

Боловсрол, шинжлэх ухаан, оюуны өмчийн статистик мэдээллийг батлагдсан маягтаар цуглуулж, жил, сар бүрийн бюллетень, танилцуулга, жилийн эмхэтгэлд тусган нийтийн хүртээл болгож байна.

Эдгээр статистикийн мэдээллийг Засгийн газрын мөрийн хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг дүгнэх, салбарын нэмэгдэл өртгийн тооцоо хийх, хүлээгдэж буй гүйцэтгэлийг тооцох, тогтвортой хөгжлийн зорилт, бүх нийтийн боловсрол (Education for all) хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд, хүний хөгжлийн үзүүлэлтүүдийг тооцоход ашиглаж байгаагаас гадна ЮНЕСКО-гоос жил бүр гаргадаг эмхэтгэлд боловсролын салбарын хүртээмжийн, дотоод үр ашгийн, үр дүнгийн, санхүүгийн болон хүний нөөцийн үзүүлэлтийг ЮНЕСКО-гоос боловсруулсан аргачлалын дагуу тооцон оруулж байна.